



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

┌ Албан томилолтоор ажиллуулах тухай ┐


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5.5, Нийслэлийн 2015 оны эдийн засаг, нийгмийн зорилтын 3.4.1.1, "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн 2.1.14, 2.3.11, 2.3.15, тус газрын дүрмийн 2.3, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлалын менежмент, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын хөгжлийн загвар, жуулчны баазын байгаль орчинд ээлтэй технологийн шийдлийг судалж нэвтрүүлэх зорилгоор Дундговь, Өмнөговь аймагт тус газрын мэргэжилтнүүдийг 2015 оны 05-р сарын 08-10-ны өдрүүдэд албан томилолтоор ажиллуулах ажлыг зохион байгуулахыг дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн /Э.Мөнхзул/, хот орчмын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн /Б.Ербахыт/ нарт даалгасугай.

2. Албан томилолтын хугацаанд мэргэжилтнүүдийн хийж гүйцэтгэх ажлын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийн задаргааг хоёрдугаар хавсралтаар баталсугай.


3. Албан томилолтын зардал болох 896,000 /найман зуун ерэн зургаан мянга/ төгрөгийг дотоод албан томилолтын зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2015 оны 05 сарын
06 өдрийн ~~135~~ тоот тушаалын .../ хавсралт



ДУНДГОВЬ, ӨМНӨГОВЬ АЙМАГТ АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Зорилго:

Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлалын менежмент, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын хөгжлийн загвар, жуулчны баазын байгаль орчинд ээлтэй технологийн шийдлийг судалж нэвтрүүлэх

Хугацаа:

2015 оны 05-р сарын 8-11-ны өдрүүдэд

Хамрах хүрээ:

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүд, Өмнөговь аймгийн аялал жуулчлал эрхлэгчид, "Гайхамшигт говь" аялал жуулчлалын холбооны гишүүд

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Өмнөговь аймгийн Даланзадгад хот, Булган сумын зочид буудал, жуулчны баазуудад үйлчилгээний менежментийн сургалт явуулах, гарын авлага бэлтгэж өгөх
- Өмнөговь аймгийн аялал жуулчлал эрхлэгчдийн зөвлөгөөнд оролцох
- Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжүүлж буй туршлагатай танилцах, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт нэвтрүүлэх боломжийг судлах. Үүнд:
 - Орон нутгийн иргэдийн нөхөрлөлийн үйл ажиллагаатай танилцах
 - Дэлхийн шилдэг 25 эко жуулчны баазын нэгээр шалгарсан "Говийн гурван тэмээ" жуулчны баазын үйл ажиллагаатай танилцах, тус баазын цэвэр, бохир ус, бие засах газар, цахилгаан дулааны асуудлаа байгаль орчинд ээлтэй, шилдэг технологи ашиглан шийдвэрлэсэн байдалтай танилцах
 - Жуулчдад морь, тэмээ унуулж орон нутгийн хөтөч хийдэг иргэдийн зохион байгуулалт, жуулчдын аюулгүй байдлыг хангах талаар авч хэрэгжүүлж буй ажилтай танилцах
 - Байгалийн дагалт баялаг ашиглан хийсэн замын тэмдэг тэмдэглэгээ, жуулчны мэдээллийн самбар, амрах цэгийн тохижилттой танилцах
- ОХУ, БНХАУ, Монгол гурван улсын хамтран хэрэгжүүлж буй "Цайны зам" төслийн маршрутын дагуух үзмэрүүдийн нөхцөл байдалтай танилцах

Хүрэх үр дүн:

Дээрх ажлуудыг хийж гүйцэтгэснээр дараах үр дүнд хүрнэ.


- Өмнөговь аймаг, Говь гурвансайханы аялал жуулчлалын цогцолборт газрын аялал жуулчлалын ололт, дэвшилтэт ажлуудыг Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт нэвтрүүлэх боломжтой болно.
- Жишиг эко жуулчны баазыг хот орчимд бий болгох, жуулчны баазын стандартыг сайжруулах, шинэчлэх боломжтой болно.
- Налайх дүүргийн 6 дугаар хороо буюу Горхи-Тэрэлжийн тусгай хамгаалалттай нутагт аялал жуулчлалын жишиг эко баазуудыг бий болгох боломж бүрдэнэ.

Хийж гүйцэтгэх ажлын чиглэл:

| № | Хамрах хүрээ, чиглэл | Багийн гишүүд | Багийн дугаар |
|---|---|----------------------------|---------------|
| 1 | Өмнөговь аймгийн Аялал жуулчлалын холбооны даргатай уулзаж, хэрэгжүүлж байгаа ажлууд, цаашид дотоодын аялал жуулчлалын чиглэлээр хамтарч хэрэгжүүлэх ажлуудыг талаар уулзаж ярилцах- | Э.Баттулга Б.Амарзаяа | 1-р баг |
| 2 | Өмнөговь аймагт аялал жуулчлалын чиглэлээр хэрэгжүүлж байгаа томоохон төсөл хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл цуглуулах | Б.Халиун Н.Халиун | |
| 3 | Өмнөговь аймгийн аялал жуулчлалын салбарын маркетингийн суваг, аялал жуулчлалын сурталчлах чиглэлээр хэрэгжүүлж байгаа үлгэр жишээч ажлуудыг судлах, дэмжлэг үзүүлэх | М.Болортуяа Д.Монголхүү | |
| 4 | Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хийж ажлуудыг талаар мэдээлэл цуглуулах, хамтарч хэрэгжүүлж болох ажлуудын чиглэлийг тодорхойлох | Н.Алтанзаяа | |
| 5 | Мэдээллийн төвд тавих Өмнөговь аймгийн аялал жуулчлалын байгууллагын талаар хамгийн сүүлийн үеийн мэдээлэл, статистик судалгаа, зурагт хуудас, жуулчдад хэрэгтэй бусад мэдээлэл цуглуулах, авч очих | Д.Энхбаяр Б.Жаргалан | |
| 6 | Өмнөговь аймгийн аялал жуулчлалын зөвлөгөөнд мэдээлэл бэлдэж оролцох | М.Баасандорж Э.Мөнхзул | 2-р баг |
| 7 | Дэлхийн эко жуулчны баазын стандартыг хангасан "Говь гурван тэмээ" жуулчны баазын үйлчилгээний чанарын талаар судалгаа хийх | С.Туул Д.Ганболд | |
| 8 | Сургалт явуулах, сургалтын материал бэлдэх | Ш.Ундармаа С.Нина | |

| | | | |
|----|--|----------------|--|
| 9 | Энгийн жуулчны баазыг эко жуулчны баазтай харьцуулж мэдээлэл гаргах | С.Нина | |
| 10 | Хот орчимд эко жуулчны бааз бий болгох боломжийг судлах | Б.Ербахыт | |
| 11 | Шинэ үйлчилгээг бий болгож, орчныг тохижуулж байгаа хэлбэрийг судлах | Д.Жаргалсайхан | |

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2015 оны 5 сарын 25 өдрийн
№35 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



**ДУНДГОВЬ, ӨМНӨГОВЬ АЙМАГТ АЛБАН
ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ТӨСӨВ**

| № | Зардлын зүйл | Нэгж зардал /төгрөгөөр/ | Тоо хэмжээ | Нийт зардал /төгрөгөөр/ |
|----|---|----------------------------|------------|----------------------------|
| 1. | Албан томилолтын зардал /Төрийн захиргааны албан хаагч 14 ажилтан/ | 29.000 | 2 | 812.000 |
| 2. | Албан томилолтын зардал /Төрийн үйлчилгээний албан хаагч 3 ажилтан/ | 14.000 | 2 | 84.000 |
| | БҮГД | | | 846.000 |

Хянасан: Ахлах нягтлан бодогч

П.Ариунаа

Боловсруулсан: Мэргэжилтэн

Э.Мөнхзул